



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар A/63

Хөхөө

**Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/395 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Сумын хэмжээнд Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд бүх охин төл, тугал, хурга, ишгийг хамруулах ажлыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд чанартай зохион байгуулж, ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж “Арвин хөхөө” ХХК-ны захирал (О.Гал-Эрдэнэ), “Дончхүү” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эзэн (Б.Нарханд) нарт даалгасугай.

2.Дархлаажуулалтын ажилд хяналт тавьж, эмч мэргэжилтэнүүдийг заавар зөвлөмжөөр ханган ажиллахыг сумын мал эмнэлгийн тасгийн Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Өлзийсайхан), Тархвар зүйч (Л.Бумбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ж. Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ



C My Documentts-2024-CZD-ZAHIRAMJ-A